

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/48/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Утас:70543179 Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан	15
3.1 Ерөнхий зүйл	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Материаллаг байдал.....	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....	20
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт.....	21
4.3 Албан шаардлага	22
4.4 Зөвлөмж.....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2022.02.25 № 30
танай _____ -ны № _____ -т

Г БАЯНТАЛ СУМЫН “4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГ”-ИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Ч.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтал сумын “4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянтал сумын “4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянтал сумын “4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 9,495.4 мянган төгрөгийн дараах алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,089.2 мянган төгрөгөөр их байна.

- Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 7,153.5 мянган төгрөгийн авлага, өглөгийг тусгасан,
- Эзэн холбогдогчийг олж тогтоолгүй шууд данснаас хассан,
- Хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг нийт 1,841.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.9 дэх заалт, УСНББОУС-14, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 хавсралтын 4, Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10.9 дүгээр

4208020091

тушаалыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/ төгрөгөөр /
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,766,334.25	35,829,118.89
2	АВЛАГА	3,332,532.34	3,250,429.34
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	661,592.96	579,489.96
4	Бусад авлага	2,670,939.38	2,670,939.38
5	Байгууллагаас авах авлага	2,115,121.98	2,115,121.98
6	Хувь хүмүүсээс авах авлага	555,817.4	555,817.4
7	УРЬДЧИЛГАА	150,000	150,000
8	Урьдчилгаа тооцоо	150,000	150,000
9	Цалингийн урьдчилгаа	150,000	150,000
10	БАРАА МАТЕРИАЛ	31,283,801.91	32,428,689.55
11	Хангамжийн материал	31,283,801.91	32,428,689.55
12	Бичиг хэргийн материал	10,000	
13	Аж ахуйн материал	6,180,710	6,434,428.64
14	Хүнсний материал	1,335,247.7	1,316,560.7
15	Бусад хангамжийн материал	23,757,844.21	24,677,700.21
16	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	429,315,218.31	415,795,929.68
17	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	429,315,218.31	415,795,929.68
18	Биет хөрөнгө	429,105,051.72	415,779,763.13
19	Барилга, байгууламж, орон сууц	396,197,966.24	396,197,966.24
20	Хуримтлагдсан элэгдэл	-24,236,997.96	-36,217,996.92
21	Машин тоног төхөөрөмж(компьютер)	49,101,375	49,629,375
22	Хуримтлагдсан элэгдэл	-24,780,283.69	-33,052,216.55
23	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,820,650.5	36,370,650.5
24	Хуримтлагдсан элэгдэл	-2,710,354.4	-6,164,111.17
25	Бусад үндсэн хөрөнгө	5,169,800	5,169,800
26	Хуримтлагдсан элэгдэл	-220,000.02	-916,600.02
27	Ном	4,762,896.05	4,762,896.05
28	Биет бус хөрөнгө	210,166.59	16,166.55
29	Програм хангамж	582,000	582,000
30	Хуримтлагдсан элэгдэл	-371,833.41	-565,833.45
31	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	464,081,552.56	451,625,048.57
32	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,760,979.02	3,753,090.62
33	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,760,979.02	3,753,090.62
34	Өглөг	3,760,979.02	3,753,090.62
35	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,546,186.77	2,546,186.77
36	Бусад өглөг	1,214,792.25	1,206,903.85
37	Байгууллагад төлөх өглөг	7,888.4	
38	Хувь хүмүүст төлөх өглөг	1,206,903.85	1,206,903.85
39	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	460,320,573.54	447,871,957.95
40	Засгийн газрын хувь оролцоо	460,320,573.54	447,871,957.95

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59,214,677.62	59,214,677.62
42	Хуримтлагдсан үр дүн	204,367,493.22	191,918,877.63
43	Өмнөх үеийн үр дүн	187,298,099.46	203,007,979.78
44	Тайлант үеийн үр дүн	17,069,393.76	-11,089,102.15
45	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,738,402.7	196,738,402.7
46	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	464,081,552.56	451,625,048.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	246,235,137	227,732,265.64
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,808,837	11,826,765.64
3	Нийтлэг татварын бус орлого	40,808,837	11,826,765.64
4	Торгуулийн орлого	242,213	
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	31,719,675	11,078,000
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,846,949	748,765.64
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,426,300	215,905,500
8	Улсын төвлөрсөн төсвөөс	175,532,300	183,254,100
9	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	175,532,300	183,254,100
10	Нэмэлт санхүүжилтийн орлого		145,000
11	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		145,000
12	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,894,000	32,506,400
13	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,894,000	32,506,400
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	229,165,743.24	238,821,367.79
15	УРСГАЛ ЗАРДАЛ	229,165,743.24	238,821,367.79
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,367,218.24	230,304,840.63
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,562,945	146,994,380
18	Үндсэн цалин	132,411,797	146,994,380
19	Нэмэгдэл	151,148	
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,041,956	19,452,804.28
21	Тэтгэврийн даатгал	11,587,959	13,568,485.28
22	Тэтгэмжийн даатгал	1,372,950	1,520,609
23	ҮОМШӨ-ний даатгал	1,088,279	1,176,168
24	Ажилгүйдлийн даатгал	272,070	289,775
25	Эрүүл мэндийн даатгал	2,720,698	2,897,767
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,871,002	28,728,965.16
27	Гэрэл, цахилгаан	2,146,470	1,619,787.16
28	Түлш, халаалт	20,748,860	23,574,530
29	Цэвэр, бохир ус	1,975,672	3,534,648
30	Хангамж, бараа материалын зардал	17,532,729.08	4,905,991
31	Бичиг хэрэг	1,479,000	1,155,900
32	Тээвэр, шатахуун	332,900	195,000
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000	25,900
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,755,850	3,529,191
35	Бараа материал акталсны зардал	12,714,979.08	
36	Нормативт зардал	11,082,586.71	5,833,325
37	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000	34,400

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

38	Хоол, хүнс	10,822,586.71	5,798,925
39	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000	
40	Томилолт, зочны зардал		41,500
41	Дотоод албан томилолт		41,500
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,580,000	426,000
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	280,000	186,000
44	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000	
45	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	240,000
46	Бараа үйлчилгээний бусад зардал	19,695,999.45	23,921,875.19
47	Бараа үйлчилгээний бусад зардал	43,000	85,000
48	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		599,100
49	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,652,999.45	23,237,775.19
50	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,798,525	8,516,527.16
51	Бусад урсгал шилжүүлэг		860,000
52	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		860,000
53	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,839,398	461,434.84
54	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,839,398	461,434.84
55	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,959,127	7,195,092.32
56	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,959,127	7,195,092.32
57	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	17,069,393.76	-11,089,102.15
58	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	17,069,393.76	-11,089,102.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,403.7	187,298,099.46	443,251,180.78
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,214,677.62	196,738,403.7	187,298,099.46	443,251,180.78
3	Тайлант үеийн үр дүн			17,069,393.76	17,069,393.76
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.7	204,367,493.22	460,320,573.54
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.7	204,367,493.22	460,320,573.54
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-1,359,513.44	-1,359,513.44
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.7	203,007,979.78	458,961,060.1
8	Тайлант үеийн үр дүн			-11,089,102.15	-11,089,102.15
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	59,214,677.62	196,738,402.7	191,918,877.63	447,871,957.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	205,426,300	215,905,500
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	205,426,300	215,905,500
3	Улсын төвлөрсөн төсвөөс	175,532,300	183,254,100
4	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	175,532,300	183,254,100
5	Нэмэлт санхүүжилтийн орлого		145,000
6	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		145,000
7	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,894,000	32,506,400
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,894,000	32,506,400
9	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,036,300	215,905,500
10	УРСГАЛ ЗАРДАЛ	203,036,300	215,905,500
11	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,237,775	207,388,972.84
12	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,831,323	150,781,981.28
13	Үндсэн цалин	112,201,980	90,740,391.28
14	Нэмэгдэл	19,264,401	53,023,510
15	Унаа хоолны хөнгөлөлт		
16	Урамшуулал	4,364,942	7,018,080
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,413,500	15,583,100
18	Тэтгэврийн даатгал	10,441,029	11,114,520.7
19	Тэтгэмжийн даатгал	1,263,800	1,147,593.49
20	ҮОМШӨ-ний даатгал	1,011,800	891,194.38
21	Ажилгүйдлийн даатгал	253,100	260,891.37
22	Эрүүл мэндийн даатгал	2,443,771	2,168,900.06
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,871,002	28,728,965.16
24	Гэрэл, цахилгаан	2,146,470	1,619,787.16
25	Түлш, халаалт	20,748,860	23,574,530
26	Цэвэр, бохир ус	1,975,672	3,534,648
27	Хангамж, бараа материалын зардал	2,670,800	394,800
28	Бичиг хэрэг	100,000	51,400
29	Тээвэр, шатахуун	1,021,300	195,000
30	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000	37,900
31	Ном, хэвлэл		37,400
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,299,500	73,100
33	Нормативт зардал	16,037,300	6,152,426.4
34	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,000	34,400
35	Хоол, хүнс	15,621,000	5,788,126.4
36	Нормын хувцас, зөөлөн эдлэл	326,300	329,900
37	Эд хогшил, урсгал засварын зардал	443,600	3,316,000
38	Урсгал засвар	443,600	3,316,000
39	Томилолт, зочны зардал		41,500

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

40	Дотоод албан томилолт		41,500
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,767,100	636,600
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	467,100	416,600
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000	
44	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	220,000
45	Бараа үйлчилгээний бусад зардал	1,203,150	1,753,600
46	Бараа үйлчилгээний бусад зардал		85,000
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,203,150	1,668,600
48	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,798,525	8,516,527.16
49	Бусад урсгал шилжүүлэг		860,000
50	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		860,000
51	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,839,398	461,434.84
52	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,839,398	461,434.84
53	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,959,127	7,195,092.32
54	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,959,127	7,195,092.32
55	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,390,000	
56	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,390,000	
57	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,390,000	
58	Дотоод эх үүсвэрээр	2,390,000	
59	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,390,000	
60	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,390,000	
61	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,760,500	208,103,972.84	7,656,527.16
2	УРСГАЛ ЗАРДАЛ	215,760,500	208,103,972.84	7,656,527.16
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,900,500	207,243,972.84	7,656,527.16
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	154,850,500	150,781,981.28	4,068,517.72
5	Үндсэн цалин	110,119,200	90,740,391.28	19,378,808.72
6	Нэмэгдэл	35,402,800	53,023,510	-17,620,710.0
7	Унаа хоолны хөнгөлөлт	1,122,700		1,122,700
8	Урамшуулал	8,205,800	7,018,080	1,87,720
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,583,100	15,583,100	
10	Тэтгэврийн даатгал	12,561,000	11,114,520.7	1,446,479.30
11	Тэтгэмжийн даатгал	764,500	1,147,593.49	-383,093.49
12	ҮОМШӨ-ний даатгал	610,900	891,194.38	-280,294.38
13	Ажилгүйдлийн даатгал	156,600	260,891.37	-104,291.37
14	Эрүүл мэндийн даатгал	1,490,100	2,168,900.06	-678,800.06
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,190,400	28,728,965.16	461,434.84
16	Гэрэл, цахилгаан	3,500,000	1,619,787.16	1,880,212.84
17	Түлш, халаалт	23,190,400	23,574,530	-384,130
18	Цэвэр, бохир ус	2,500,000	3,534,648	-1,034,648
19	Хангамж, бараа материалын зардал	394,800	394,800	
20	Бичиг хэрэг	51,400	51,400	
21	Тээвэр, шатахуун	195,000	195,000	
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,900	37,900	
23	Ном, хэвлэл	37,400	37,400	
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,100	73,100	
25	Нормативт зардал	9,279,000	6,152,426.4	
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,400	34,400	
27	Хоол, хүнс	8,914,700	5,788,126.4	3,126,573.60
28	Нормын хувцас, зөөлөн эдлэл	329,900	329,900	
29	Эд хогшил, урсгал засварын зардал	3,316,000	3,316,000	
30	Урсгал засвар	3,316,000	3,316,000	
31	Томилолт, зочны зардал	41,500	41,500	
32	Дотоод албан томилолт	41,500	41,500	
33	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	576,600	576,600	

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

34	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	356,600	356,600	
35	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	220,000	
36	Бараа үйлчилгээний бусад зардал	1,668,600	1,668,600	
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,668,600	1,668,600	
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	860,000	860,000	
39	Бусад урсгал шилжүүлэг	860,000	860,000	
40	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	860,000	860,000	
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215,760,500	208,103,972.84	
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	183,254,100	176,059,007.68	-
				32,044,965.16
43	Улсын төсвөөс санхүүжих			
44	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	183,254,100	176,059,007.68	7,195,092.32
45	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,506,400	32,044,965.16	461,434.84
46	Орон нутгийн төсвөөс	32,506,400	32,044,965.16	461,434.84
47	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	129	129	129
48	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1
49	Төсвийн байгууллага	1	1	1
50	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	13	13
51	Удирдах ажилтан	1	1	1
52	Гүйцэтгэх ажилтан	6	6	6
53	Үйлчлэх ажилтан	6	6	6
54	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	102	102	102
55	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	102	102	102
56	Төрийн өмчит СӨБ байгууллага	102	102	102
57	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13	13	13
58	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	7	7	7
59	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		145,000	-145,000
3	УРСГАЛ ЗАРДАЛ		145,000	-145,000
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		145,000	-145,000
5	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		60,000	-60,000
6	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		60,000	-60,000
7	Бараа үйлчилгээний бусад зардал		85,000	-85,000
8	Бараа үйлчилгээний бусад зардал		85,000	-85,000
9	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		145,000	-145,000
10	Нэмэлт санхүүжилтийн орлого		145,000	-145,000
11	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		145,000	-145,000

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн ашиглалт, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 02 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” нь сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг олон улсын хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан боловсронгуй болгох юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузель сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал” сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний 229,165.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,437.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2,406.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг”-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,456.5 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	3,332.5	3,250.4	-82.1
Урьдчилгаа	150.0	150.0	0.0
Бараа материал	31,283.8	32,428.7	1,144.9
Үндсэн хөрөнгө	429,315.2	415,795.9	-13,519.3
Нийт хөрөнгө	464,081.5	451,625.0	-12,456.5
Өр төлбөр	3,760.9	3,753.0	-7.9

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	59,214.7	59,214.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	204,367.5	191,918.9	-12,448.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,738.4	196,738.4	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	464,081.5	451,625.0	-12,456.5

Авлагын дансны үлдэгдэл болох 3,250.4 мянган төгрөг нь өмнөх жилүүдэд хуримтлагдсан, тооцоо нийлсэн актаар баталгаажуагүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,428.7 мянган төгрөг болж 1,144.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал болон бусад хангамжийн материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 415,795.9 мянган төгрөг болж 13,519.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь тайлант хугацаанд нийт 11,078.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Баянтал сумын ОНХС-аас 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №А/125 дугаар захирамжаар 10,550.0 мянган төгрөгийн хүүхдийн ширээ, сандлыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өгсөн 528.0 мянган төгрөгийн принтерийг данс бүртгэлд нэмж бүртгэсэн байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 191,918.9 мянган төгрөг болж, 12,448.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр”-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 18,502.8 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилт, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 9,655.7 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардал, бараа ажил үйлчилгээ бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн залруулга нь өмнөх үеэс 1,359.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсонтой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 246,235.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 246,235.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,885.7 мянган төгрөгөөр бууруулж 224,349.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс бууруулж баталсан нь цалин хөлс, тогтмол зардал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 /Сургуулийн өмнөх боловсрол/ хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 224,349.4 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвийн хуваарийг 6 удаагийн өөрчлөлт орсны дараа 183,254.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэг, 32,506.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 215,760.5 мянган төгрөгөөс тусгай зориулалтын шилжүүлгээс 183,254.1 мянга, орон нутгийн төсвөөс 32,506.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 208,104.0 мянган төгрөгийг зарцуулж, 7,656.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 208,104.0 мянга буюу 96.4 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 4,068.5 мянга, тогтмол зардлаас 461.4 мянга, нормативт зардлаас 3,126.6 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 3 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 7,656.5 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц сангаас 145.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний

зардалд 60.0 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 85.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг” нь 2021 онд нийт 242,869.7 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан ба 13 мэдээлэл хоцроосон, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлсэн тайлан огт мэдээлээгүй, тэтгэмж олгосон 2 тушаалын 860.0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 27,109.2 мянган төгрөгийг мэдээлээгүй зөрчил илэрсэн тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгахад хуульд нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 53,919.6 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс 45,191.6 мянган төгрөгийн 10 алдааг аудитын явцад залруулж, 537.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 8,190.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 1 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	01	-	-	-
Албан шаардлага	2	8,190.9	1	1,179.5	1	7,011.4	
Төлбөрийн акт	2	537.1	2	537.1			
Нийт дүн	5	8,728.0	4	1,716.6	1	7,011.4	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 54,785.2 мянган төгрөгийн 19 алдаа зөрчил илэрснээс, 225.6 мянган төгрөгийн 4 алдааг завсрын аудитаар, 12,067.7 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 2,496.2 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 32,842.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 7,153.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 12,293.3 мянган төгрөгийн залруулгаас 225.6 завсрын аудитаар, 12,067.7 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Харуул ажилтай А.Батсайханд 8 сард ажилласан илүү цагийн цалинг 160.4 мянган төгрөгийг олгохоор завсрын аудитаар зөвлөмж өгсний дагуу олгож залруулсан.
2. Цалингийн зардлыг 65.2 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасныг завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу залруулсан.
3. Бараа материалын тайланг хөдөлгөөн гараагүй ч үлдэгдэлтэй тайланг сар бүр тайлан гаргах зөвлөмж өгсний дагуу залруулга хийгдсэн.
4. Барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад биет бус хөрөнгийн нярвын тайланг гаргаагүйг улирал бүр үлдэгдэлтэй тайланг гаргах талаар завсраар өгсөн зөвлөмжийн дагуу залруулсан.

5. Цалингийн зардлыг 2,298.4 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасныг залруулсан.
6. 1 жилээс дээш ашиглагдах 519.9 мянган төгрөгийн бараа материалыг бусад хангамж материал дансанд бүртгэж залруулга хийгдсэн.
7. Үндсэн хөрөнгийн элэгдэл нь 2,095.9 мянган төгрөгөөр дутуу тооцогдсоныг залруулсан
8. Нягтлан бодох бүртгэлийн алдаанаас үүссэн эсэхийг нотлох баримтгүй, үндэслэлгүй шийдвэрээр нийт 7,153.5 мянган төгрөгийн авлага, өглөгийг данснаас хасаж, өмнөх үеийн үр дүн дансыг бууруулсан дансны бичилтийг буцааж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг нийт 1,841.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралт 2.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 хавсралтын 4, Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10,9 дүгээр тушаалын 10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

2. Нярав Э.Энхсайханд бичиг хэргийн ажил хавсран ажилласны 1,050.0 мянган төгрөгийн нэмэгдлийг олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

3. Албан хаагчдад хууль, тогтоомжид заагдаагүй буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон ба 86.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2-т нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн зөрүү 204.0 мянган төгрөгийн тооцооллыг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтууд, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, эрх ба үүрэг байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 АЛБАН ШААРДЛАГА

- 4.3.1. Татварын цахим бүртгэлийн системд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтыг тулган баталгаажуулаагүйгээс 1,926.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

- 4.3.2. ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин ажлын хувцас 259.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Мөн байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй бөгөөд халаалтын зардлыг 2,730.0 мянган төгрөг буюу 13%-иар нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

- 4.3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 13 мэдээллийг хугацаа хоцроосон, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг огт мэдээлээгүй, тэтгэмж олгох 860.0 мянган төгрөгийн 2 тушаалыг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ болох 27,969.2 мянган төгрөгийн талаар мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.4.4, 6.4.8, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2.9, 3.2.11, 3.2.14 дэх заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн ба “иж бүрэн байх, оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх болон шаардлага хангаагүй үндсэн хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулах

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 7,153.5 мянган төгрөгийн авлага, өглөгийг тусгасан, эзэн холбогдогчийг олж тогтоогоогүй шууд данснаас хассан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.9, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн ба “иж бүрэн байх, оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаанд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	19	55,513.6	8	12,293.4	5	3,181.4	4	32,885.3	2	7,153.5